



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 803

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 19 нэрийн, нийт 82,912,307.00 (наян хоёр сая есөн зуун арван хоёр мянга гурван зуун долоо) төгрөгийн балансын үнэ, үлдэх өртөг бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Хил хамгаалах ерөнхий газрын дарга бригадын генерал Х.Лхагвасүрэн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Т.Сүхболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



123007441
37-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
...805... дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгө бүртгэлтэй Хил хамгаалах ерөнхий газар,
Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэн өгөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Нийт хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Хүлээн авах байгууллага
1	Суурин компьютер /иж бүрдэл/ New Dell Optiplex 7000 tower	2023	10	3,799,200.00	37,992,000.00	0.00	37,992,000.00	Хил хамгаалах ерөнхий газарт
2	Энгэрийн камер-Boblow KJ21pro 32gb	2023	10	511,390.00	5,113,900.00	0.00	5,113,900.00	
3	ширээ-REAIM COMMAND W ETE20090	2023	1	806,403.00	806,403.00	0.00	806,403.00	
4	дугуйтай тумбочка-REAI-DS-MP3DR-MPED-B1	2023	1	438,393.00	438,393.00	0.00	438,393.00	
5	туслах ширээ-REAI-CMR-ESR14055-SRETURN-B2	2023	1	818,148.00	818,148.00	0.00	818,148.00	
6	сэтгүүлийн ширээ-REAI-CMR-LT09060-COFFTAB-B1	2023	1	332,688.00	332,688.00	0.00	332,688.00	
7	хурлын ширээ-240см	2023	1	1,072,623.00	1,072,623.00	0.00	1,072,623.00	
8	хувцасны шүүгээ-HIGHCAB-B1	2023	1	1,292,733.00	1,292,733.00	0.00	1,292,733.00	
9	шилэн хаалгатай модон шүүгээ-REAI-CMR-BS205290-HIGHCAB-B1	2023	1	1,342,323.00	1,342,323.00	0.00	1,342,323.00	
10	намхан шүүгээ-REAI-CMR-OS82190-MEDCAB-B1	2023	1	602,388.00	602,388.00	0.00	602,388.00	
11	Сандал-OASIS-HIGH-BM573H-Black	2023	1	896,013.00	896,013.00	0.00	896,013.00	
12	бичгийн ширээ-WILS-MP5-1570-TAB-B1	2023	5	469,713.00	2,348,565.00	0.00	2,348,565.00	
13	зүүдэг тумбочка-WILS-MP5-H3-PED-B1	2023	5	291,363.00	1,456,815.00	0.00	1,456,815.00	

14	шилэн хаалгатай босоо шүүгээ-WILS-MP5-8042GD-CAB-B4	2023	6	1,264,813.00	7,588,878.00	0.00	7,588,878.00	
15	Хувцасны шкаф-WILS-MP5-8042WD-CAB-B4	2023	6	1,201,910.00	7,211,460.00	0.00	7,211,460.00	
16	дугуйтай сандал-GYM-86176D-BLACK-LOWMESH-B1	2023	5	247,863.00	1,239,315.00	0.00	1,239,315.00	
17	баллонтой ус ордог төхөөрөмж-TOSHIBA RWF-W1766TMN-K	2023	1	599,900.00	599,900.00	0.00	599,900.00	
	Дүн		57		71,152,545.00	0.00	71,152,545.00	Цагдаагийн ерөнхий газарт
1	Суурин компьютер /иж бүрдэл/ New Dell Optiplex 7000 tower	2023	2	3,799,200.00	7,598,400.00	0.00	7,598,400.00	
2	Зөөврийн компьютер-Dell Latitude 3420	2023	1	4,161,362.00	4,161,362.00	0.00	4,161,362.00	
	Дүн		3		11,759,762.00	0.00	11,759,762.00	
	Нийт дүн		60		82,912,307.00		82,912,307.00	
	Нийт дүн		60		82,912,307.00 (наян хоёр сая есөн зуун арван хоёр мянга гурван зуун долоон)		82,912,307.00 (наян хоёр сая есөн зуун арван хоёр мянга гурван зуун долоон)	